



ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

- | | | |
|-----|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----|
| 65. | Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын цаазаар авах ялыг халахад чиглэсэн Нэмэлт II Протоколд нэгдэн орох тухай | 290 |
| 66. | Хэлэлцээр соёрхон батлах тухай | 291 |
| 67. | Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл шинээр олгохыг хориглох тухай | 291 |

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- | | | | |
|-----|----------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------|-----|
| 68. | Үндсэн хуулийн цэцийн 2011 оны 04 дүгээр дүгнэлтийн тухай | Дугаар 03 | 291 |
| 69. | ““Шинэ бүтээн байгуулалт” дунд хугацааны зорилгот хөтөлбөр батлах тухай” тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай | Дугаар 04 | 292 |
| 70. | Үндсэн хуулийн цэцийн 2011 оны 03 дугаар дүгнэлтийн тухай | Дугаар 05 | 294 |

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

- | | | | |
|-----|------------------------------------------------------|------------|-----|
| 71. | Монгол төрийн галыг бадраах тухай | Дугаар 239 | 294 |
| 72. | Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай | Дугаар 05 | 295 |
| 73. | Үндсэн хуулийн хичээл заах тухай | Дугаар 10 | 295 |
| 74. | Зарим хүмүүсийг шүүгчийн албан тушаалд томилох тухай | Дугаар 11 | 296 |

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- | | | | |
|-----|------------------------|------------|-----|
| 75. | Хэлэлцээр батлах тухай | Дугаар 308 | 296 |
|-----|------------------------|------------|-----|



76.	Журам батлах тухай	Дугаар 309	297
77.	Нийтлэг журам батлах тухай	Дугаар 311	303
78.	Төрийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах зарим арга хэмжээний тухай	Дугаар 312	309
79.	Аж ахуйн нэгж, байгууллагын 2011 оны тооллогын дүн, цаашид авах арга хэмжээний тухай	Дугаар 315	313
80.	Төлөвлөгөө батлах тухай	Дугаар 317	314
81.	Газрын тосны зарим бүтээгдэхүүний онцгой албан татварын тухай	Дугаар 318	321
82.	Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Дугаар 324	322
83.	Мэргэжлийн боловсрол, сургалтын талаар авах зарим арга хэмжээний тухай	Дугаар 326	323

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2012 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр

Улаанбаатар хот

**ИРГЭНИЙ БОЛОН УЛС ТӨРИЙН ЭРХИЙН
ТУХАЙ ОЛОН УЛСЫН ПАКТЫН ЦААЗААР
АВАХ ЯЛЫГ ХАЛАХАД ЧИГЛЭСЭН
НЭМЭЛТ II ПРОТОКОЛД НЭГДЭН
ОРОХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын цаазаар авах ялыг халахад чиглэсэн Нэмэлт II Протоколд Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр нэгдэн орсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭЛ



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2012 оны 01 дүгээр
сарын 06-ны өдөр

Улаанбаатар
хот

ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улс, Бүгд Найрамдах Унгар Улс хооронд байгуулсан Нийгмийн хамгааллын хэлэлцээрийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2012 оны 01 дүгээр
сарын 12-ны өдөр

Улаанбаатар
хот

АШИГТ МАЛТМАЛЫН ХАЙГУУЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ШИНЭЭР ОЛГОХЫГ ХОРИГЛОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Ашигт малтмалын тухай хуульд заасан хайгуулын тусгай зөвшөөрөл шинээр олгохыг 2012 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл хориглосугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2012 оны 01 дүгээр сарын 12-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2012 оны 01 дүгээр
сарын 05-ны өдөр

Дугаар 03

Улаанбаатар
хот

Үндсэн хуулийн цэцийн 2011 оны 04 дүгээр дүгнэлтийн тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.4 дэх заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Татварын зарим хууль болон Нийгмийн даатгалын тухай хуулийг



хэрэгжүүлэх тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийн “нийгмийн даатгалын шимтгэл”, 3 дугаар зүйлийн 3.1.5 дахь заалтын “Нийгмийн даатгалын тухай хуулийн 20.1.1”, мөн зүйлийн 3.2 дахь хэсгийн “нийгмийн даатгалын шимтгэл”, 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсгийн “нийгмийн даатгалын шимтгэл”, мөн зүйлийн 4.3.11 дэх заалтын “нийгмийн даатгалын шимтгэл” гэж тус тус заасан нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 5 дахь заалтын “өндөр наслах, хөдөлмөрийн чадвар алдах, хүүхэд төрүүлэх, асрах болон хуульд заасан бусад тохиолдолд эд, мөнгөний тусламж авах эрхтэй”, мөн зүйлийн 6 дахь заалтын “эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрхтэй.” гэснийг тус тус зөрчсөн байна” гэсэн Үндсэн хуулийн цэцийн 2011 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн 04 дүгээр дүгнэлтэд заасныг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсүгэй.

2.Энэ тогтоолыг 2012 оны 01 дүгээр сарын 05-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2012 оны 01 дүгээр
сарын 12-ны өдөр

Дугаар 04

Улаанбаатар
хот

**““Шинэ бүтээн байгуулалт” дунд хугацааны
зорилтот хөтөлбөр батлах тухай” тогтоолын
хавсралтад өөрчлөлт оруулах тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Шинэ бүтээн байгуулалт” дунд хугацааны зорилтот хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын 2010 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн 36 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“Монгол Улсын Их Хурлын 2010 оны
36 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

**“ШИНЭ БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ” ДУНД ХУГАЦААНЫ
ЗОРИЛТОТ ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ
ХОЛБОГДУУЛАН УЛСЫН ИХ ХУРАЛД ӨРГӨН
МЭДҮҮЛЭХ ХУУЛЬ, УЛСЫН ИХ ХУРЛЫН БУСАД
ШИЙДВЭРИЙН ТӨСЛИЙН ЖАГСААЛТ**

Нэг.Шинээр батлах хуулийн төслийн жагсаалт:



1. Нийслэл хотын татварын тухай хуулийн төсөл;
2. Хотыг дахин хөгжүүлэх /төлөвлөх/ тухай хуулийн төсөл;
3. Хог хаягдлыг хаях, ангилах, устгах, дахин ашиглах тухай хуулийн төсөл;
4. Орон сууцны санхүүжилтийн тухай хуулийн төсөл;
5. Бүсийн нэмэгдлийн тухай хуулийн төсөл;
6. Авто зогсоолын тухай хуулийн төсөл;
7. Хот, суурины ногоон байгууламжийн тухай хуулийн төсөл.

Хоёр. Шинэчлэн найруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн жагсаалт:

1. Хот байгуулалтын тухай хууль;
2. Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль;
3. Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль;
4. Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль;
5. Төсвийн тухай хууль;
6. Газрын тосны бүтээгдэхүүний тухай хууль;
7. Автотээврийн тухай хууль;
8. Барилгын тухай хууль;
9. Газрын тухай хууль;
10. Авто замын тухай хууль;
11. Захиргааны хариуцлагын тухай хууль;
12. Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль;
13. Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөрийн тухай хууль;
14. Ойн тухай хууль;
15. Иргэний бүртгэлийн тухай хууль;
16. Бүсчилсэн хөгжлийн удирдлага, зохицуулалтын тухай хууль;
17. Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хууль;
18. Газрын төлбөрийн тухай хууль.

Гурав. Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл:

1. “Нийслэл хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

_____ооОо_____”

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭЛ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2012 оны 01 дүгээр
сарын 12-ны өдөр

Дугаар 05

Улаанбаатар
хот

Үндсэн хуулийн цэцийн 2011 оны 03 дугаар дүгнэлтийн тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.4 дэх заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2011 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн 03 дугаар дүгнэлтийн Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.9.1 дэх заалтын “гэмт үйлдлийнх нь явцад, эсхүл гэмт хэргийн газарт эд мөрийн баримттай нь баривчилж, улмаар бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх тухай саналыг Улсын ерөнхий прокурор Улсын Их Хуралд оруулсан” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна”, мөн зүйлийн 2 дахь хэсгийн “Хүнийг ... эрхэлсэн ажил, албан тушаал...-аар нь ялгаварлан гадуурхаж үл болно”, Хорин есдүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “Улсын Их Хурлын гишүүн гэмт хэрэгт холбогдсон тухай асуудлыг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэж, бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэхийг шийдвэрлэнэ” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2011 оны 12 дугаар
сарын 28-ны өдөр

Дугаар 239

Улаанбаатар
хот

Монгол төрийн галыг бадраах тухай

Хүн ардынхаа үндэсний ухамсар, гүн ухааны үзэл санааг сэргээн төлөвшүүлэх, хүний эрх, эрх чөлөө, үндэснийхээ эв нэгдлийг эрхэмлэн дээдлэх зорилгоор Монгол Улсын Их Хурлын гишүүдээс гаргаж буй саналыг дэмжиж Үндсэн хуулийн гучин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12 дахь хэсгийг баримтлан ЗАРЛИГ БОЛГОХ нь:

1. Монгол Улс үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээн



мандуулсны 100 жилийн их ойн өдөр буюу 2011 оны 12 дугаар сарын 29-нд Монгол төрийн тулгын галыг бадраасугай.

2. Төр улс, түмэн олныхоо цог золбоо, хийморь лундааг бататгах, үндэсний уламжлалт ёс заншлаа эрхэмлэх үүднээс жил бүрийн 12 дугаар сарын 29-ний өдөр өөрсдийн тулгын галаа бадрааж байхыг төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, айл өрх бүрт уриалсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Ц.ЭЛБЭГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2012 оны 01 дүгээр
сарын 09-ний өдөр

Дугаар 05

Улаанбаатар
хот

**Элчин сайдыг эгүүлэн татах,
томилох тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, “Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай” хуулийн 14 дүгээр зүйлийн 3, “Дипломат албаны тухай” хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Япон Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Рэнцэндоогийн Жигжидийг эгүүлэн татаж, Монгол Улсаас Япон Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Содовжамцын Хүрэлбаатарыг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Ц.ЭЛБЭГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2012 оны 01 дүгээр
сарын 12-ны өдөр

Дугаар 10

Улаанбаатар
хот

**Үндсэн хуулийн хичээл
заах тухай**

Үндсэн хуулиа сахиж хүндэтгэх, хууль дээдлэх ёсыг төлөвшүүлэх, Үндсэн хуулийн мөн чанар, үзэл баримтлал, хэм хэмжээг хүүхэд, залуучуудад гүнзгий танин мэдүүлэх зорилгоор Монгол Улсын Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалт, Ерөнхийлөгчийн



тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12 дахь хэсгийг баримтлан ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн боловсролын сургуулийн оюутнууд болон ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдад жил бүрийн нэгдүгээр сарын 13-ны өдөр (хэрэв энэ өдөр бүх нийтийн амралтын өдөр тохиовол түүний өмнөх ажлын өдөр) Үндсэн хуулийн тухай нэг цагийн хичээл заах зохион байгуулалтын арга хэмжээ авахыг Монгол Улсын Засгийн газар (Ерөнхий сайд С.Батболд) – т чиглэл болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ
ЦАХИАГИЙН
ЭЛБЭГДОРЖ**

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД
СҮХБААТАРЫН
БАТБОЛД**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2012 оны 01 дүгээр
сарын 12-ны өдөр

Дугаар 11

Улаанбаатар
хот

Зарим хүмүүсийг шүүгчийн албан тушаалд томилох тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, Шүүхийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Мөнхөөгийн Эрдэнэ-Очирыг Хөвсгөл аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн, Алтангэрэлийн Бямбажавыг Нийслэлийн Багануур дүүргийн шүүхийн шүүгчийн албан тушаалд тус тус томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Ц.ЭЛБЭГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2011 оны 11 дүгээр
сарын 2-ны өдөр

Дугаар 308

Улаанбаатар
хот

Хэлэлцээр батлах тухай

Олон улсын гэрээний тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

2011 оны 6 дугаар сарын 29-ний өдөр Украин Улсын Киев хотод



гарын үсэг зурсан “Соёлын салбарт хамтран ажиллах тухай” Монгол Улсын Засгийн газар, Украин Улсын сайд нарын Танхим хоорондын хэлэлцээрийг баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАТБОЛД

**БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ
УХААНЫ САЙД**

Ё.ОТГОНБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2011 оны 11 дүгээр
сарын 2-ны өдөр

Дугаар 309

Улаанбаатар
хот

Журам батлах тухай

Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах тухай хуулийн 10.1.4, 10.1.7, 10.1.10, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 12¹.2-т заасныг үндэслэн Улсын Их Хурлын 2011 оны 11 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсийн гэр хорооллын айл өрхөд цахилгаан эрчим хүчний үнийн урамшуулал олгох журам”-ыг 1 дүгээр, “Агаарын бохирдлыг бууруулах, дулаан алдагдлыг багасгах, цахилгаан эрчим хүч хэмнэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад урамшуулал олгох журам”-ыг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсийн гэр хорооллын айл өрхийн цахилгаан эрчим хүчний үнийн урамшууллын зөрүүг улсын төсөвт тусган эрчим хүчний байгууллагад олгож байхыг Сангийн сайд С.Баярцогтод даалгасугай.

3. Агаарын бохирдлыг бууруулах, дулаан алдагдлыг багасгах, цахилгаан эрчим хүч хэмнэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад урамшуулал олгоход шаардагдах хөрөнгийг Цэвэр агаарын сангаас гаргахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Л. Гансүхэд зөвшөөрсүгэй.

4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллан, агаарын бохирдлыг бууруулах ажлын үр дүнгийн талаар жил бүрийн 6 дугаар сард Засгийн газарт танилцуулж байхыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Л.Гансүх, Эрдэс баялаг, эрчим хүчний сайд Д.Зоригт, Нийслэлийн



Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Г.Мөнхбаяр нарт үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАТБОЛД

**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН САЙД**

Л.ГАНСҮХ

**ЭРДЭС БАЯЛАГ, ЭРЧИМ
ХҮЧНИЙ САЙД**

Д.ЗОРИГТ

Засгийн газрын 2011 оны 309 дүгээр
тогтоолын 1 дүгээр хавсралт

**НИЙСЛЭЛИЙН АГААРЫН ЧАНАРЫГ САЙЖРУУЛАХ
БҮСИЙН ГЭР ХОРООЛЛЫН АЙЛ ӨРХӨД ЦАХИЛГААН
ЭРЧИМ ХҮЧНИЙ ҮНИЙН УРАМШУУЛАЛ
ОЛГОХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан нөхцөл, шалгуурын аль нэгийг хангасан болон нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсийн гэр хорооллын айл өрх (цаашид “хэрэглэгч” гэх)-д уг хуулийн 10.1.4-т заасан цахилгаан эрчим хүчний үнийн урамшуулал олгох үйл ажиллагааг энэхүү журмаар зохицуулна.

Хоёр. Урамшуулалд хамрагдах хүрээ

2.1. Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах тухай хуулийн 6.1.1-6.1.8 дахь заалтуудад заасан нөхцөл, шалгуурын аль нэгийг хангасан болон нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсийн гэр хорооллын хэрэглэгчийн хүйтний улиралд (ахуйн хэрэглээний болон халаалтын зориулалтаар) хэрэглэсэн цахилгаан эрчим хүчний үнийг 50 хувиар бууруулж урамшуулна.

2.2. Хүйтний улирлын үргэлжлэх хугацаа, цахилгааны шөнийн тариф мөрдөгдөх хугацаа, урамшуулалд хамрагдах хэрэглэгчийн цахилгааны хэрэглээний дээд хязгаарыг (зөвхөн цахилгаан халаагуур хэрэглэж байгаа болон ахуйн хэрэглээний гэсэн ялгавартайгаар) цахилгаан дамжуулах, түгээх сүлжээний хүчин чадал, техникийн боломжоос хамааруулан Эрчим хүчний зохицуулах газар жил бүрийн 6 дугаар сард багтаан тогтоож байна.

2.3. Цахилгаан эрчим хүчний үнийн урамшуулалд хамрагдах хэрэглэгчид тавигдах нөхцөл, шалгуурыг дараахь байгууллага тогтооно:



2.3.1. дулаалга сайтай болон байгаль орчинд ээлтэй, эрчим хүчний хэмнэлттэй байшин, амины орон сууц бүхий хэрэглэгчийн барилгад тавигдах нөхцөл, шалгуурыг холбогдох норм нормативын хүрээнд барилгын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага;

2.3.2. цахилгаан дамжуулах сүлжээнд холбогдсон цахилгаан болон бүх төрлийн хийн түлшээр ажилладаг халаагуур хэрэглэж байгаа; газрын гүний дулаан, нар, салхи зэрэг сэргээгдэх эрчим хүчийг ашиглаж байгаа; шахмал болон хагас коксон түлш хэрэглэж байгаа хэрэглэгчид тавигдах нөхцөл, шалгуурыг холбогдох норм нормативын хүрээнд түлш, эрчим хүчний асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага;

2.3.3. дулаалгатай гэр, сайжруулсан зуух, яндангийн шүүлтүүр болон түлш хэмнэх замаар хүлэмжийн хийн ялгарлыг багасгаж, энэ чиглэлийн дотоод, гадаадын хөнгөлөлттэй зээл, тусламж, төсөл, хөтөлбөрт хамрагдаж байгаа хэрэглэгчид тавигдах нөхцөл, шалгуурыг холбогдох норм нормативын хүрээнд Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, түүний харьяа байгууллага.

2.4. Нийслэлийн мэргэжлийн хяналтын байгууллага нь энэхүү журмын 2.3-т заасны дагуу холбогдох байгууллагын тогтоосон шалгуурыг баримтлан зохих нөхцөл, шалгуурыг хангасан хэрэглэгчид хөнгөлөлт, урамшуулал эдлэх тодорхойлолт гаргаж өгнө.

Гурав. Цахилгааны үнийн урамшуулал олгох,
санхүүжүүлэх үйл ажиллагаа

3.1. Энэхүү журмын 2.4-т заасан тодорхойлолт бүхий хэрэглэгч нь цахилгааны үнийн урамшуулалд хамрагдах тухай хүсэлтээ цахилгаан эрчим хүчээр хангагч байгууллагад гаргана.

3.2. Цахилгаан эрчим хүчээр хангагч байгууллага цахилгааны үнийн урамшуулалд хамрагдах хэрэглэгчтэй “Цахилгааны үнийн урамшуулал олгох гэрээ” байгуулна.

3.3. Нийслэлийн Засаг даргын Тамгын газар нь цахилгаан эрчим хүчээр хангагч байгууллагатай хамтран цахилгааны үнийн урамшуулалд зарцуулах хөрөнгийг урьдчилан тооцож, жил бүрийн төсөвт зохих журмын дагуу тусгуулах ажлыг зохион байгуулна.

3.4. Төсөв, санхүүгийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нь тухайн онд цахилгааны үнийн урамшуулал олгоход шаардагдах хөрөнгийн тооцоог нэгтгэн, жил бүрийн Монгол Улсын төсвийн тухай хуульд тусгуулан шийдвэрлүүлсний үндсэн дээр цахилгаан эрчим хүчний урамшууллын зөрүүг эрчим хүчний байгууллагад олгоно.



Дөрөв. Цахилгаан эрчим хүчээр хангагч байгууллага,
хэрэглэгчийн эрх, үүрэг

4.1. Цахилгаан эрчим хүчээр хангагч байгууллага нь нийслэлийн гэр хорооллын цахилгаан дамжуулах болон түгээх сүлжээг өргөтгөж шинэчлэхтэй холбогдсон судалгаа, тооцоог хийсний үндсэн дээр цахилгаан дамжуулах болон түгээх сүлжээг өргөтгөх, хүчин чадлыг нэмэгдүүлэх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх арга хэмжээ авна.

4.2. Цахилгаан эрчим хүчээр хангагч байгууллага нь цахилгааны үнийн урамшуулал олгосон тайлан мэдээг гаргаж холбогдох газруудад тайлагнана.

4.3. Хэрэглэгч нь стандартын шаардлага хангасан баталгаажсан тоолуур, цахилгаан хэрэгсэлтэй байна.

4.4. Хэрэглэгч нь сар бүрийн цахилгаан эрчим хүчний төлбөрийг тогтоосон хугацаанд төлөх бөгөөд цахилгаан эрчим хүчний төлбөрийн өргүй байна.

Тав. Хяналт тавих, хариуцлага

5.1. Цахилгааны үнийн урамшуулалд хамрагдсан хэрэглэгчтэй байгуулсан "Цахилгааны үнийн урамшуулал олгох гэрээ"-ний биелэлтэд Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах үндэсний хорооны салбар хороод хяналт тавина.

5.2 Эрчим хүчний тухай хууль, Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах тухай хууль, цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм, бусад холбогдох дүрэм, журмыг зөрчсөн тохиолдолд цахилгаан эрчим хүчээр хангагч байгууллагын санаачилгаар "Цахилгааны үнийн урамшуулал олгох гэрээ"-г цуцална.

5.3. Энэхүү журмыг зөрчсөн хэрэглэгч, хуулийн этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэж, учирсан хохирлыг нөхөн төлүүлнэ.

Засгийн газрын 2011 оны 309 дүгээр
тогтоолын 2 дугаар хавсралт

**АГААРЫН БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ, ДУЛААН АЛДАГДЛЫГ
БАГАСГАХ, ЦАХИЛГААН ЭРЧИМ ХҮЧ ХЭМНЭХ ЧИГЛЭЛЭЭР
ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА ИРГЭН, АЖ АХУЙН
НЭГЖ, БАЙГУУЛЛАГАД УРАМШУУЛАЛ ОЛГОХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах болон эрчим хүчний хэмнэлтийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж

ахуйн нэгж, байгууллагад урамшуулал олгохтой холбогдсон харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Агаарын бохирдлыг бууруулах гэдэгт дараахь үйл ажиллагааг ойлгоно:

1.2.1. агаар бохирдуулах бодисын агууламж агаарын чанарын стандартаас хэтэрч, агаарын чанар доройтохоос урьдчилан сэргийлэх зорилгоор түлшний шаталтаас гаралтай утааны хэмжээ болон түүнд агуулагдах зарим бодисын ялгарлыг багасгах;

1.2.2. авто тээврийн хэрэгслийг шатдаг хий, цахилгаан эх үүсвэрт шилжүүлэх замаар тэдгээрийн ашиглалтын улмаас ялгарах хорт утааг бууруулах;

1.2.3. эрчим хүчний хэмнэлт буюу нэгж бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үйлчилгээ болон барилгын нэгж талбайд ноогдох эрчим хүчний хэрэглээг бууруулах чиглэлээр дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх.

Хоёр. Урамшуулах шалгуур

2.1. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын агаарын бохирдлыг бууруулах, эрчим хүчний хэмнэх үйл ажиллагаанд дараахь үзүүлэлтийг шалгуур болгоно:

2.1.1. агаарын бохирдлыг бууруулах болон барилга байгууламжийн эрчим хүчний хэрэглээний үр ашгийг нэмэгдүүлэх чиглэлээр (нар, салхи, газрын гүний дулаан, бүх төрлийн хийн түлш, шингэн түлш, дулаалгын материал, цахилгаан халаагуур болон дэвшилтэт техник, технологи бүхий бүтээгдэхүүн), тоног төхөөрөмж импортлох болон үйлдвэрлэж зах зээлд тогтвортой нийлүүлж байгаа;

2.1.2. үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хувьд агаарын бохирдлыг бууруулах, эрчим хүчний хэмнэлтийг сайжруулж, үр ашгийг нэмэгдүүлэх бүтээгдэхүүн, тоног төхөөрөмж ашиглах, тухайлбал бүх төрлийн хийн түлш, шингэн түлш, нар, салхи, газрын гүний дулаан зэрэг сэргээгдэх эрчим хүч хэрэглэсэн болон дулаалгын материал, цахилгаан халаагуур, мөн дэвшилтэт техник, технологи бүхий бусад бүтээгдэхүүн, тоног төхөөрөмжийг ашиглан үйл ажиллагаа явуулж байгаа;

2.1.3. энэхүү журмын 2.1.1, 2.1.2-т заасан үйлдвэрлэл, үйлчилгээ, бүтээгдэхүүн, тоног төхөөрөмж нь хэрэглэгчдийн сэтгэл ханамжид нийцэж байгаа нь судалгаагаар тогтоогдсон.

2.2. Энэхүү журмын 2.1.1, 2.1.2-т дурдсан үйлдвэрлэл, үйлчилгээ нь агаар бохирдуулагч эх үүсвэрээс гарах бохирдуулагч бодисын хэмжээ стандартын шаардлагыг бүрэн хангасан, эсхүл 50 болон түүнээс дээш хувиар бууруулсан нь үндэсний болон олон улсын итгэмжлэгдсэн лабораториор баталгаажсан, эрчим хүчний хэмнэлт, үр ашгийн тооцоог үндэсний чадавхи бүхий байгууллагаар хийлгэж, агаарын бохирдлыг



бууруулан, эрчим хүчийг хэмнэж байгааг баталгаажуулсан, байгаль орчинд болон хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй болохыг эрх бүхий мэргэжлийн байгууллагын дүгнэлтээр нотолсон нөхцөлд урамшуулал олгоно.

Гурав. Урамшууллын хэлбэр

3.1. Энэ журамд заасан шалгуур үзүүлэлтийг хангасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг хяналтын зөвлөлийн шийдвэрийн дагуу дараахь хэлбэрээр урамшуулна:

3.1.1. тухайн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөлд “НОГООН БҮТЭЭГДЭХҮҮН”, “НОГООН ҮЙЛЧИЛГЭЭ” гэрчилгээ олгож цаашид өөрийн бараа бүтээгдэхүүн, үйлчилгээнд дээрх бичиг дүрслэл бүхий шошго 2 жилийн хугацаатай хэрэглэх эрхийг олгох;

3.1.2. дээрх гэрчилгээ авсан бараа бүтээгдэхүүн, үйлчилгээг дотоодын зах зээлийн орчинд хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах;

3.1.3. эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх, барилгын дулаалгыг сайжруулах төсөл, сэргээгдэх эрчим хүч, бүх төрлийн хийн түлш, цэвэр технологийг хөгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээнд Цэвэр агаарын сангаас дэмжлэг үзүүлж урамшуулах;

3.1.4. гэрчилгээ авсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллага хүсэлт гаргавал гадаад, дотоодоос хөрөнгө оруулалтын зориулалтаар зээл, тусламж авахад нь зохих журмын дагуу дэмжлэг үзүүлэх.

Дөрөв. Урамшуулах үйл ажиллагаа

4.1. Урамшуулал олгохдоо дараахь байгууллагын саналыг үндэслэнэ:

4.1.1. дулаалга сайтай болон байгаль орчинд ээлтэй, эрчим хүчний хэмнэлттэй байшин, амины орон сууц бүхий барилгад тавигдах нөхцөл, шалгуурыг хангасан эсэхэд барилгын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага;

4.1.2. хийн болон шингэн түлш, тэдгээрийн тоног төхөөрөмж, газрын гүний дулаан, нар, салхины болон бусад сэргээгдэх эрчим хүч, тэдгээрийн тоног төхөөрөмжид тавигдах нөхцөл, шалгуурыг хангасан эсэхэд түлш, эрчим хүчний хүчний асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага.

4.2. Энэ журамд заасан шалгуур үзүүлэлтийг хангасан тухай материалыг жил бүрийн 4, 10 дугаар сард багтаан хороо, дүүрэг, Нийслэлийн агаарын чанарын албаар дамжуулан байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хүлээн авна.

4.3. Байгаль орчны, түлш, эрчим хүчний, барилгын, эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, Мэргэжлийн



хяналтын ерөнхий газар, Нийслэлийн Захирагчийн ажлын алба, мөн энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус болон хувийн хэвшлийн байгууллагын төлөөлөл оролцсон 9 хүний бүрэлдэхүүнтэй хяналтын зөвлөл нь жилд 2 удаа буюу 5, 11 дүгээр сард хуралдаж иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн саналд дүн шинжилгээ хийж, энэ журмын 4.1-д заасан саналыг үндэслэн дүгнэлт гаргаж тухайн сарын 20-ны дотор байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд хүргүүлсэн байна.

4.4. Орон тооны бус хяналтын зөвлөлийн гишүүдийг байгаль орчин, эрчим хүчний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүдийн хамтарсан тушаалаар 2 жилийн хугацаатайгаар томилно.

4.5. Шалгарсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад гэрчилгээ олгох шийдвэрийг жил бүрийн 6 болон 12 дугаар сарын 10-ны дотор байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн гаргана.

4.6. Цэвэр агаарын сангийн тухайн жилийн урамшуулал олгох зардалд энэхүү журамд заасан урамшуулал олгохтой холбогдсон хөрөнгийг тусгаж, Цэвэр агаарын сангийн удирдах зөвлөлөөр батлуулна.

Тав. Хариуцлага

5.1. Урамшуулал олгох асуудалтай холбогдсон маргааныг Нийслэлийн агаарын чанарын алба хүлээн авч дүгнэлт гаргана.

5.2. Нийслэлийн агаарын чанарын албаны дүгнэлтийг эс зөвшөөрвөл шүүхэд хандана.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2011 оны 11 дүгээр
сарын 9-ний өдөр

Дугаар 311

Улаанбаатар
хот

Нийтлэг журам батлах тухай

Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 6.4-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 7.2, 8.2.1-д заасны дагуу харьяа байгууллага, аж ахуйн нэгж, өөрийн аппаратад дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журмыг батлан мөрдүүлэхийг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

3. Аж ахуйн нэгж, байгууллагын дотоод хяналт шалгалт



хариуцсан ажилтнуудыг Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо болон холбогдох мэргэжлийн холбоодтой хамтран нэгдсэн сургалтад хамруулах ажлыг зохион байгуулахыг Мэргэжлийн хяналтын ерөнхий газар (Р.Содхүү)-т, сургалтыг зохион байгуулахад шаардагдах хөрөнгийг Монгол Улсын Шадар сайдын төсвийн багцад тусган санхүүжүүлэхийг Сангийн сайд С.Баярцогтод тус тус даалгасугай.

4. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан “Нийтлэг журам батлах тухай” Засгийн газрын 1995 оны 12 дугаар сарын 6-ны өдрийн 228 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАТБОЛД

**МОНГОЛ УЛСЫН
ШАДАР САЙД**

М.ЭНХБОЛД

Засгийн газрын 2011 оны 311 дүгээр
тогтоолын хавсралт

**АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД
ДОТООД ХЯНАЛТ ШАЛГАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ
НИЙТЛЭГ ЖУРАМ**

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Энэхүү нийтлэг журмын зорилго нь аж ахуйн нэгж, байгууллагын хэмжээнд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Төрийн хяналт шалгалтад хамрагдах өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллага (цаашид “аж ахуйн нэгж, байгууллага” гэх) энэхүү нийтлэг журмыг дагаж мөрдөнө.

1.3. Аж ахуйн нэгж, байгууллага нь энэхүү нийтлэг журамд нийцүүлэн, өөрийн үйл ажиллагааны онцлогт тохирсон “Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам”-тай байна.

1.4. Төрийн болон орон нутгийн өмчийн аж ахуйн нэгж, байгууллагын “Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам”-ыг Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 7.2, 8.2.1-д заасны дагуу дараахь эрх бүхий этгээд батална:

1.4.1. хуульд өөрөөр заагаагүй бол яам, эрхлэх ажлын



хүрээнд нь үйл ажиллагаа явуулж байгаа агентлаг, харьяа бусад байгууллага, аж ахуйн нэгжид мөрдөх “Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам”-ыг Монгол Улсын сайд;

1.4.2. өөрийн болон доод шатны Засаг даргын ажлын алба, харьяа байгууллага, аж ахуйн нэгжид мөрдөх “Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам”-ыг аймаг, нийслэлийн Засаг дарга.

1.5. Энэхүү журмын 1.4-т зааснаас бусад тохиолдолд “Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам”-ыг тухайн байгууллага, аж ахуйн нэгж өөрөө баталж мөрдөнө.

1.6. Аж ахуйн нэгж, байгууллага нь дотоод хяналт шалгалтыг зохион байгуулахдаа энэхүү нийтлэг журам болон Монгол Улсын хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газар, эрх бүхий бусад байгууллага, албан тушаалтнаас нийтээр дагаж мөрдүүлэхээр гаргасан шийдвэрийг удирдлага болгоно.

1.7. Хуульд өөрөөр заагаагүй бол аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод аудит, хяналт-шинжилгээ, үнэлгээ (мониторинг) хийхэд энэхүү нийтлэг журам хамаарахгүй.

Хоёр. Дотоод хяналт шалгалтын зарчим,
зорилго, хамрах хүрээ

2.1. Дотоод хяналт шалгалт нь хууль дээдлэх, хараат бус, ил тод, шударга, бодитой, хөндлөнгийн аливаа нөлөөллөөс ангид байх зарчимд тулгуурлана.

2.2. Дотоод хяналт шалгалтын зорилго нь аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаа, үйлдвэрлэсэн болон борлуулж байгаа бараа, бүтээгдэхүүн, үзүүлж байгаа ажил, үйлчилгээ нь хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэр, эрх бүхий бусад байгууллага, албан тушаалтны болон өөрийн гаргасан шийдвэрт нийцэж байгаа эсэхэд аж ахуйн нэгж, байгууллагын хэмжээнд хяналт тавьж илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах, гэм буруутай этгээдэд хариуцлага хүлээлгэхэд чиглэнэ.

2.3. Дотоод хяналт шалгалтыг зохих удирдамж, төлөвлөгөөний дагуу гүйцэтгэж, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг бүрэн хамарсан байвал зохино.



Гурав. Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах
нэгж, ажилтан, түүний эрх үүрэг

3.1. Энэхүү журмын 1.3-т заасан “Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам”-д өөрөөр заагаагүй бол дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах үүргийг тухайн аж ахуйн нэгж, байгууллагын захиргааны асуудал хариуцсан нэгж, ажилтан (цаашид “дотоод хяналт шалгалтын нэгж, ажилтан” гэх) гүйцэтгэнэ.

3.2. Дотоод хяналт шалгалтын нэгж, ажилтан нь тухайн аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагад шууд захирагдах бөгөөд зохион байгуулалтын хувьд бусад бүтэц, нэгжээс хараат бус байна.

3.3. Дотоод хяналт шалгалтын ажилтан нь тухайн аж ахуйн нэгж, байгууллагын эрхэлж байгаа үйл ажиллагааны чиглэлээр боловсрол, мэргэжил эзэмшиж мэргэшсэн, ажлын дадлага туршлагатай байна.

3.4. Дотоод хяналт шалгалтын нэгж, ажилтан нь тухайн аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны онцлог, үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэл, хэмжээ, зохион байгуулалтын бүтэц, харьяалагдах нэгж, объектын тоог харгалзан тухайн жилд хийх хяналт шалгалтын ажлын тусгайлсан төлөвлөгөөг боловсруулан эрх бүхий албан тушаалтнаар батлуулан мөрдөж ажиллана.

3.5. Дотоод хяналт шалгалтын нэгж, ажилтан нь хяналт шалгалтын ажлын дүн, авсан арга хэмжээний талаар улиралд нэгээс доошгүй удаа тухайн аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагын хурлаар хэлэлцүүлж, шаардлагатай бол шийдвэр гаргуулан хамт олонд мэдээлнэ.

3.6. Дотоод хяналт шалгалтын нэгж, ажилтан нь эрх бүхий албан тушаалтны баталсан удирдамжийн дагуу дотоод хяналт шалгалтыг гүйцэтгэнэ.

3.7. Дотоод хяналт шалгалтын нэгж, ажилтан нь дараахь нийтлэг эрх, үүрэгтэй байна:

3.7.1. зохих удирдамж, төлөвлөгөөний дагуу дотоод хяналт шалгалтыг гүйцэтгэж, дүнг тайлагнах;

3.7.2. хяналт шалгалт явуулахдаа аж ахуйн нэгж, байгууллагын салбар, нэгжийн удирдлагатай шууд харилцаж, тэдгээрээс шаардлагатай мэдээ, судалгаа гаргуулах, холбогдох ажилтны ажлыг шалгаж танилцах, илэрсэн зөрчил, дутагдлын талаар тайлбар гаргуулах;



3.7.3. илэрсэн зөрчил, дутагдлын шалтгаан нөхцөлийг тодруулан зөрчлийг арилгуулах, дахин гаргуулахгүй байх талаар арга хэмжээ авах;

3.7.4. шаардлагатай бол илэрсэн зөрчил, дутагдлын шалтгаан нөхцөлийг арилгах асуудлаар болон зөрчил гаргасан этгээдэд хариуцлага ногдуулах талаар байгууллагын удирдлагад санал тавьж шийдвэрлүүлэх;

3.7.5. хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэр, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон эрх зүйн актыг өөрийн байгууллагад сурталчлах, хэрэгжүүлэх талаар сургалт зохион байгуулах;

3.7.6. хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчлийг арилгах, урьдчилан сэргийлэх талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх;

3.7.7. холбогдох дүрэм, журам, байгууллагын стандартыг боловсронгуй болгох талаар судалгаа, дүгнэлт гаргах;

3.7.8. дотоод хяналт шалгалтын үр нөлөө болон мэргэжлийн чадавхийг дээшлүүлэх зорилгоор хөндлөнгийн хяналтын байгууллагаас мэргэжил арга зүйн зөвлөгөө авах, зөрчлийг нь арилгаж чадахгүй асуудлыг хууль хяналтын эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх, хамтран ажиллах талаар санал боловсруулан удирдлагад танилцуулах;

3.7.9. байгууллагын үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэл, холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, стандартын хэрэгжилт болон зөрчлийн талаархи мэдээллээр удирдлагыг хангах;

3.7.10. хийсэн хяналт шалгалтын талаар бүртгэл хөтөлж, мэдээллийн сан бүрдүүлэх;

3.7.11. дотоод хяналт шалгалтаар хүний амь нас, эрүүл мэнд, нийгэм болон хүрээлэн байгаа орчны аюулгүй байдалд шууд буюу шууд бусаар ноцтой аюул, хор хохирол учруулж болохуйц нөхцөл байдал үүссэн нь тогтоогдвол түүнийг арилгах арга хэмжээг нэн даруй авч, эрх бүхий байгууллагад мэдэгдэх.

3.8. Энэ журмын 3.7-д зааснаас бусад эрх, үүргийг тухайн аж ахуйн нэгж, байгууллагын “Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам”-д тусгана.



3.9. Энэхүү журмын 3.7-д заасан эрх, үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан дотоод хяналт шалгалтын нэгж, ажилтанд аливаа дарамт, шахалт үзүүлэх, үйл ажиллагаанд нь хөндлөнгөөс нөлөөлөхийг хориглоно.

Дөрөв. Дотоод хяналт шалгалтын үйл ажиллагаа

4.1. Дотоод хяналт шалгалтыг дараахь чиглэлээр зохион байгуулна:

4.1.1. хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэр, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон эрх зүйн актын хэрэгжилт болон тухайн аж ахуйн нэгж, байгууллагын хуулиар хүлээсэн үүргийн хэрэгжилтэд тавих хяналт шалгалт;

4.1.2. аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны байгаль орчинд үзүүлэх нөлөөлөлд хийх хяналт шалгалт;

4.1.3. үйлдвэрлэж байгаа болон борлуулж байгаа бараа, бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний чанарт тавих хяналт шалгалт;

4.1.4. хөдөлмөрийн нөхцөл, аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлага, хөдөлмөрийн дотоод журмын биелэлтэд тавих хяналт шалгалт;

4.1.5. өмчийн бүртгэл тооцоо, ашиглалт, хадгалалт, хамгаалалт, санхүү бүртгэлийн үйл ажиллагаанд тавих хяналт шалгалт;

4.1.6. тухайн аж ахуйн нэгж, байгууллагын “Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам”-д тухайлан заасан бусад хяналт шалгалт.

4.2. Энэхүү журмын 4.1-д заасан чиглэлээр дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах хэлбэрийг тухайн аж ахуйн нэгж, байгууллагын “Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам”-аар зохицуулна.

Тав. Хариуцлага

5.1. Дотоод хяналт шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлын дагуу буруутай этгээдэд холбогдох хууль тогтоомж, тухайн аж ахуйн нэгж, байгууллагын дотоод журамд заасан хариуцлагыг ногдуулна.

5.2. Дотоод хяналт шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдал нь гэмт хэргийн шинжтэй бол асуудлыг хуулийн байгууллагад тавьж шийдвэрлүүлнэ.



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2011 оны 11 дүгээр
сарын 9-ний өдөр

Дугаар 312

Улаанбаатар
хот

Төрийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Тагнуулын байгууллагын тухай хуулийн 11.1.6, Харилцаа холбооны тухай хуулийн 20.3-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэн, дүнг Засгийн газарт танилцуулахыг Тагнуулын ерөнхий газрын дарга Р.Болд, Мэдээлэл, шуудан, харилцаа холбоо, технологийн газрын дарга Ж.Бат-Эрдэнэ нарт тус тус даалгасугай:

а) Улсын Их Хурлын Тамгын газар, Ерөнхийлөгчийн Тамгын газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, төрийн захиргааны төв байгууллагын мэдээллийн аюулгүй байдалд эрсдэлийн үнэлгээ хийж, цаашид эрсдэлээс хэрхэн сэргийлэх талаар төрийн албан хаагчдын дунд сургалт зохион байгуулах;

б) төрийн мэдээллийн нэгдсэн сүлжээг байгуулах, төрийн байгууллагуудын интернэт орчинг халдлагаас хамгаалах;

в) тусгай хэрэглээний мэдээлэл, холбооны сүлжээг зохион байгуулах.

2. Төрийн байгууллагуудыг кибер халдлагаас хамгаалах тогтолцоог бүрдүүлэх зорилгоор Төрийн холбооны газрыг Кибер аюулгүй байдлын газар болгон өөрчлөн зохион байгуулж, үүнтэй холбогдуулан Төрийн ордны холбоо, техникийн үйлчилгээг үндсэн хөрөнгө, орон тоо, төсвийн хамт Төрийн тусгай хамгаалалтын газарт шилжүүлэх, “Үндэсний дата төв”-ийг төрийн тусгай хамгаалалтад авах зэрэг арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Тагнуулын ерөнхий газрын дарга Р.Болдод, энэхүү үйл ажиллагаанд мэргэжил, арга зүй, техник, программ хангамжийн чиглэлээр туслалцаа үзүүлж, хамтран ажиллахыг Мэдээлэл, шуудан, харилцаа холбоо, технологийн газрын дарга Ж.Бат-Эрдэнэ, Харилцаа холбооны зохицуулах хороо (Б.Болдбаатар)-нд тус тус даалгасугай.

3. Ашиглалтын хугацаа дууссантай холбогдуулан төрийн холбооны утасгүй телефон системийг хэрэглээнээс хасч, суурин утасны үйлчилгээг холбогдох төхөөрөмж, зээлийн хамт “Монголын цахилгаан холбоо”



ХК-д шилжүүлэх асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу судалж, шийдвэрлэхийг Сангийн сайд С.Баярцогт, Тагнуулын ерөнхий газрын дарга Р.Болд, Төрийн өмчийн хороо (Д.Сугар)-нд тус тус даалгасугай.

4. Төрийн мэдээллийн нэгдсэн сүлжээнд хамрагдаж мэдээ, мэдээллийг уг сүлжээгээр дамжуулж байхыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлаг болон байгууллагын дарга нарт үүрэг болгож, холбогдох бусад төрийн байгууллагын дарга нарт зөвлөсүгэй.

5. Тусгай хэрэглээний мэдээлэл, холбооны сүлжээнд хамрагдах төр, захиргааны байгууллагын жагсаалтыг хавсралт ёсоор баталж, төрийн нууцад хамаарах мэдээ, мэдээллийг энэхүү сүлжээгээр дамжуулж байхыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нар, Монгол Улсаас гадаад улсад суугаа Дипломат төлөөлөгчийн газрын тэргүүнүүдэд үүрэг болгож, холбогдох бусад төрийн байгууллага, албан тушаалтнуудад зөвлөсүгэй.

6. Тогтоолыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын төсвийн төсөлд тусгаж байхыг Сангийн сайд С.Баярцогтод даалгасугай.

7. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Төрийн холбооны ашиглалтыг сайжруулж, төсөвт зардлыг хэмнэх зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2004 оны 1 дүгээр сарын 7-ны өдрийн 10 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАТБОЛД

**МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА**

Ч.ХҮРЭЛБААТАР

Засгийн газрын 2011 оны 312 дугаар
тогтоолын хавсралт

**ТУСГАЙ ХЭРЭГЛЭЭНИЙ МЭДЭЭЛЭЛ,
ХОЛБООНЫ СҮЛЖЭЭНД ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГА,
АЛБАН ТУШААЛТАН**

Монгол Улсын Их Хурал	
1	Улсын Их Хурлын Тамгын газар
2	Үндэсний аудитын газар



3	Үндэсний статистикийн хороо
4	Монголбанк
5	Төрийн албаны зөвлөл
6	Санхүүгийн зохицуулах хороо
7	Сонгуулийн ерөнхий хороо
8	Авлигатай тэмцэх газар
9	Хүний эрхийн үндэсний комисс
Монгол Улсын Ерөнхийлөгч	
1	Ерөнхийлөгчийн Тамгын газар
2	Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах комисс
3	Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлын алба
Монгол Улсын Засгийн газар	
1	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар (Төрийн ёслол хүндэтгэлийн өргөө)
2	Гадаад харилцааны яам
3	Сангийн яам
4	Хууль зүй, дотоод хэргийн яам
5	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
6	Батлан хамгаалах яам
7	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам
8	Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын яам
9	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам
10	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
11	Эрдэс баялаг, эрчим хүчний яам
12	Эрүүл мэндийн яам
Шүүх, прокурор	
1	Улсын дээд шүүх
2	Шүүхийн ерөнхий зөвлөл
3	Улсын ерөнхий прокурор
4	Үндсэн хуулийн цэц
Засгийн газрын агентлаг	
1	Авто замын газар
2	Авто тээврийн газар
3	Архивын ерөнхий газар



4	Ашигт малтмалын газар
5	Биеийн тамир, спортын газар
6	Гаалийн ерөнхий газар
7	Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх газар
8	Гадаадын хөрөнгө оруулалтын газар
9	Газрын тосны газар
10	Газрын харилцаа, барилга, геодези, зураг зүйн газар
11	Дипломат байгууллагын Үйлчилгээ, аж ахуйн газар
12	Жижиг, дунд үйлдвэрийн газар
13	Зэвсэгт хүчний жанжин штаб
14	Иргэний нисэхийн ерөнхий газар
15	Мал эмнэлэг, үржлийн газар
16	Мэдээлэл, шуудан, харилцаа холбоо, технологийн газар
17	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
18	Мэргэжлийн боловсрол, сургалтын газар
19	Нийгмийн даатгалын ерөнхий газар
20	Онцгой байдлын ерөнхий газар
21	Ойн газар
22	Оюуны өмчийн газар
23	Удирдлагын академи
24	Улсын бүртгэлийн ерөнхий газар
25	Усны газар
26	Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороо
27	Стандартчилал, хэмжил зүйн газар
28	Соёл, урлагийн хороо
29	Тагнуулын ерөнхий газар
30	Татварын ерөнхий газар
31	Төмөр замын газар
32	Төрийн өмчийн хороо
33	Төр, засгийн Үйлчилгээ, аж ахуйг эрхлэх газар
34	Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар
35	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар
36	Цаг уур, орчны шинжилгээний газар



37	Цагдаагийн ерөнхий газар
38	Цөмийн энергийн газар
39	Хил хамгаалах ерөнхий газар
40	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар
41	Хүүхдийн төлөө газар
42	Эрүүл мэндийн газар
43	Эрчим хүчний газар
Бусад	
1	Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар
2	Аймаг, нийслэлийн хууль, хяналтын байгууллагууд
3	Монгол Улсаас хилийн чанадад суугаа Дипломат төлөөлөгчийн газрууд

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2011 оны 11 дүгээр
сарын 9-ний өдөр

Дугаар 315

Улаанбаатар
хот

Аж ахуйн нэгж, байгууллагын 2011 оны тооллогын дүн, цаашид авах арга хэмжээний тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Аж ахуйн нэгж, байгууллагын тооллогын дүнг газар зүйн мэдээлэлтэй холбосон нэгдсэн сан бүрдүүлж, энэ оны 12 дугаар сард багтаан хэрэглэгчдэд хүргүүлэх арга хэмжээ авахыг Сангийн сайд С.Баярцогтод даалгаж, Үндэсний статистикийн хорооны дарга С.Мэндсайханд зөвлөсүгэй.

2. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн нэгдсэн сангийн мэдээллийг шинэчлэн бүрдүүлэх, үндэсний ангилал, код нэвтрүүлэх, мэдээллийн сангуудын уялдааг хангах арга хэмжээ авахыг Үндэсний статистикийн хорооны дарга С.Мэндсайханд зөвлөж, Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга Л.Мөнхбаатар, Мэдээлэл, шуудан, харилцаа холбоо, технологийн газрын дарга Ж.Бат-Эрдэнэ нарт үүрэг болгосугай.

3. Тооллогод хамрагдаагүй аж ахуйн нэгж, байгууллагыг нэгбүрчлэн судалж, тэдгээрийн бүртгэлийг хуульд нийцүүлэн цэгцлэх арга хэмжээ авахыг Сангийн сайд С.Баярцогт, Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга Л.Мөнхбаатар нарт даалгаж, Үндэсний статистикийн хорооны дарга С.Мэндсайханд зөвлөсүгэй.



4. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тогтолцоог боловсронгуй болгох чиглэлээр холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах санал боловсруулан Засгийн газрын хуралдаанд оруулахыг Тэргүүн шадар сайд Н.Алтанхуяг, Сангийн сайд С.Баярцогт нарт даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАТБОЛД

**МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА**

Ч.ХҮРЭЛБААТАР

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2011 оны 11 дүгээр
сарын 9-ний өдөр

Дугаар 317

Улаанбаатар
хот

Төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Улсын Их Хурлын 2011 оны 1 дүгээр сарын 6-ны өдрийн 2 дугаар тогтоолоор баталсан “Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөр”-ийн эхний үе шатанд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хавсралт ёсоор баталсугай.

2. Төлөвлөгөөг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын төсөвт тусган бусад эх үүсвэрээс санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Сангийн сайд С.Баярцогт, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Л.Гансүх, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Т.Бадамжунай, Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд Х.Баттулга, Эрдэс баялаг, эрчим хүчний сайд Д.Зоригт, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Ё.Отгонбаяр, Батлан хамгаалахын сайд Л.Болд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулж, салбар дундын ажлын уялдааг ханган, хяналт тавьж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Л.Гансүхэд үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАТБОЛД

**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН САЙД**

Л.ГАНСҮХ

Засгийн газрын 2011 оны 317 дугаар
тогтоолын хавсралт

**УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ЭХНИЙ ҮЕ ШТАНД
ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Авч хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа	Оролцогч талууд	
			Хариуцах байгууллага	Хамтран хэрэгжүүлэгч
Стратегийн зорилт 1: Уур амьсгалын өөрчлөлтийн улмаас гарч байгаа асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн үйл ажиллагааг дэмжсэн эрх зүйн орчин, бүтэц, зохион байгуулалт, удирдлагын тогтолцоог бүрдүүлэх талаар				
1.1	Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох стратеги боловсруулан хэрэгжүүлэх	2012	БОАЖЯ	Холбогдох яамд
1.2	Байгаль орчныг хамгаалах тухай, Ус, цаг уур, орчны хяналт-шинжилгээний тухай, Ойн тухай, Усны тухай, Эрчим хүчний тухай, Ашигт малтмалын тухай, Газрын тосны тухай, Гамшгаас хамгаалах тухай, Газрын тухай, Барилгын тухай, Сэргээгдэх эрчим хүчний тухай зэрэг холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулах	2011-2016	БОАЖЯ	ХЗДХЯ, ЭБЭХЯ, ЗТБХБЯ, ОБЕГ
1.3	Бэлчээр ашиглах, хөрс хамгаалах, эрчим хүч хэмнэх, үйлдвэрлэл, үйлчилгээний үр ашгийг дээшлүүлэх, ногоон хөгжлийг дэмжих, уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг авах хариу арга хэмжээний тухай зэрэг харилцааг зохицуулсан эрх зүйн орчныг шинээр бүрдүүлэх	2012-2016	БОАЖЯ	ЗТБХБЯ, ХХААХҮЯ, ЭБЭХЯ
1.4	Хүлэмжийн хийн тооллого, тооцоонд шаардлагатай эх мэдээг улсын статистикийн мэдээлэлд оруулах	2012-2015	ЭБЭХЯ, БОАЖЯ	ҮСХ
1.5	Эрчим хүчний үйлдвэрлэл, хэрэглээ, барилгын чанар, дулаалгын байдалд хөндлөнгийн аудит хийх механизмыг бий болгох	2012-2016	ЭБЭХЯ, ЗТБХБЯ	БОАЖЯ, МХЕГ
1.6	Эрчим хүч, уур, усны хэмнэлт, хог хаягдлын ашиглалт, боловсруулалт, тээврийн хэрэгсэл болон зарим цахилгаан хэрэгслийн хүлэмжийн хийн ялгаралтын байж болох мөрд түвшний шинэ норм, стандартыг боловсруулж мөрдүүлэх	2012-2016	ЭБЭХЯ	ҮСХ



1.7	Уур амьсгалын өөрчлөлтийн асуудал хариуцсан салбар дундын зохицуулалт хийх үүрэг бүхий бүтцийг бий болгох, чадавхижуулах арга хэмжээ авах	2012-2013	БОАЖЯ	
1.8	Уур амьсгалын өөрчлөлтөд эмзэг салбаруудын дасан зохицох үйл ажиллагааны хөтөлбөр боловсруулах (эрүүл мэнд, мал аж ахуй, газар тариалан, усны нөөц, хангамж зэрэг)	2011-2016	БОАЖЯ	Холбогдох яамд
Стратегийн зорилт 2: Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох үндэсний чадавхийг бүрдүүлж, байгаль орчны тэнцвэрт байдлыг ханган, эдийн засаг, нийгмийн эмзэг байдал, эрсдэлийг үе шаттайгаар бууруулах талаар				
2.1	Уур амьсгалын өөрчлөлтөөс хүний эрүүл мэндэд учирч хэмжээний үр дүнг дээшлүүлэх	2012-2016	ЭМЯ	БОАЖЯ
2.2	Голын эх, сав газруудын менежментийг боловсронгуй болгох үндсийг бүрдүүлэх	2011-2016	БОАЖЯ	Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар
2.3	Уур амьсгалын өөрчлөлтөд нэн эмзэг бүс нутгийн усны нөөцийг нарийвчлан тогтоох, салбарын хөгжлийн бодлого, төлөвлөлттэй уялдуулан тооцох, зарим голын савд экосистемд түшиглэсэн дасан зохицох арга хэмжээ авч эхлэх	2011-2016	ҮХШХ	БОАЖЯ
2.4	Уур амьсгалын өөрчлөлтөд зохицуулан ойн нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний менежментийг боловсронгуй болгох	2012-2016	БОАЖЯ	Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар
2.5	Газрын доройтол, цөлжилтийг сааруулах арга хэмжээг авах, бэлчээр, хөрсний хүлэмжийн хий шингээх чадавхийг дээшлүүлэх арга хэмжээ авах	2012-2016	БОАЖЯ	ХХААХҮЯ, ЗТБХБЯ
2.6	Говь, тал хээрийн бүсийн ахуйн түлшний хангамжийг зохистой шийдвэрлэх замаар заг, шаваг зэрэг модлог, бутлаг ургамлын нөөцийг хамгаалах	2012-2016	БОАЖЯ	ЭБЭХЯ, ХХААХҮЯ
2.7	Уур амьсгалын өөрчлөлтөд эмзэг биологийн олон янз байдлыг хамгаалах, дасан зохицоход дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн арга хэмжээг тусгай хамгаалалттай газар нутгийг түшиглүүлэн хэрэгжүүлж эхлэх	2012-2016	БОАЖЯ	Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар
2.8	Мал аж ахуйн эмзэг байдал, эрсдэлийг үе шаттайгаар бууруулах арга хэмжээ авах	2011-2016	ХХААХҮЯ	СЯ, НХХЯ
2.9	Хуурайшилтай нөхцөлд зохицсон, ус хэмнэх, хөрс хамгаалах технологид тулгуурласан усалгаатай газар тариаланг хөгжүүлэх	2012-2016	ХХААХҮЯ	БОАЖЯ

2.10	Газар ашиглалт, бэлчээрийн талаархи судалгааны газар дээрх болон сансрын шуурхай мониторингийг боловсронгуй болгож, орон нутгийн засаг захиргааны байгууллага, малчдад дэмжлэг үзүүлэх	2012 оноос	БОАЖЯ	ХХААХҮЯ, ОБЕГ
2.11	Иргэдийн амьжиргааг дээшлүүлэх, ядуурлыг бууруулах, ногоон ажлын байр бий болгох чиглэлээр төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх	2012-2015	НХХЯ	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар
2.12	Цөлжилтөд илүү ихээр нэрвэгдэж байгаа аймаг, орон нутгийн түлшний хэрэгцээнд шингэрүүлсэн шатдаг хий ашиглах, хийн түлшний үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгжийг дэмжихэд чиглэсэн арга хэмжээ авах	2012-2016	БОАЖЯ, ЭБЭХЯ, ХХААХҮЯ	Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар
2.13	Цөлжилтөд ихээр нэрвэгдэж байгаа аймгуудад мод, бут, сөөг, харгана түлшинд хэрэглэхийг хориглох арга хэмжээ авах	2012-2016	БОАЖЯ, ЭБЭХЯ, ХХААХҮЯ	Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар
Стратегийн зорилт 3: Байгаль орчинд ээлтэй технологи нэвтрүүлэх замаар хүлэмжийн хийн ялгаралтыг үе шаттайгаар бууруулж, карбон багатай эдийн засагт шилжих эхлэлийг тавих талаар				
3.1	Цахилгаан эрчим хүч, дулааны үйлдвэрлэлийн түлшний хувийн зарцуулалтыг бууруулах арга хэмжээ авах	2011-2016	ЭБЭХЯ	
3.2	Эрчим хүчний дамжуулалт, түгээлтийн үр ашгийг үе шаттайгаар нэмэгдүүлэх	2011-2016	ЭБЭХЯ	Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар
3.3	Салхи, нарны эрчим хүчний үйлдвэрлэл, хэрэглээг өргөжүүлэх	2011-2012	ЭБЭХЯ	
3.4	Эрчим хүчний нэгдсэн системд холбогдоогүй сумын төв, суурин сэргээгдэх эрчим хүчээр хангах арга хэмжээг шат дараатайгаар авах	2011-2016	ЭБЭХЯ	
3.5	Органик хог хаягдал боловсруулж хийн түлш үйлдвэрлэх технологи нэвтрүүлэх, хэрэглээг нэмэгдүүлэх	2012-2016	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар	
3.6	Газрын гүний дулааныг ашиглах технологийн туршилт хийх, нэвтрүүлж эхлэх	2011-2016	ЭБЭХЯ	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар
3.7	Далд уурхайн метан хийг ашиглах технологи нэвтрүүлэх судалгаа хийх	2011-2016	ЭБЭХЯ	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар
3.8	Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотын барилгын халаалтын системд Дулааны программчилсан	2011-2016	ЭБЭХЯ	



	тохируулгатай технологи нэвтрүүлэх, хот, суурины хэрэглэгчдийг бүрэн тоолууртай болгох ажлын эхний шатыг хэрэгжүүлэх				
3.9	Улайсах лампын хэрэглээг хязгаарлах арга хэмжээг шат дараатай авах	2012-2016	ЭБЭХЯ	ГЕГ	
3.10	Цементийн үйлдвэрлэлд хуурай технологи нэвтрүүлэх	2012-2016	ЗТБХБЯ		
3.11	Автогээвэрт хийн болон хосолмол түлшний хэрэглээг нэмэгдүүлэх, түлш бага зарцуулдаг тээврийн хэрэгслийн хэрэглээг дэмжих арга хэмжээ авах	2012-2016	ЗТБХБЯ		
3.12	Нийтийн зоригч тээврийн үйлчилгээнд том оврын автобус, цахилгаан тээврийн хэрэгслийн эзлэх хувийг нэмэгдүүлэх	2012-2016	ЗТБХБЯ	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар	
3.13	Улаанбаатар хотын дулааны алдагдал ихтэй хуучин барилгыг нэмж Дулаалах, Дулааны алдагдлыг багасгах арга хэмжээ авах	2011-2016	ЗТБХБЯ		
3.14	Газар ашиглалтыг сайжруулж, атарсан газрыг сэргээн ашиглах явдлыг өргөжүүлэх, шинээр газар хагалахыг хязгаарлах арга хэмжээ авах, уул уурхайн газрын нөхөн сэргээлтийг сайжруулах	2011-2016	БОАЖЯ	ХХААХҮЯ	
3.15	Ойжуулах, ойг нөхөн сэргээх болон ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлж, хүлэмжийн хийн шингээлтийг сайжруулах	2011-2016	БОАЖЯ		
3.16	Ойг түймэр, хортон шавжаас хамгаалах, хууль бус ашиглалтыг таслан зогсоох, ойн нөөцийн хомсдолыг бууруулахад чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх	2011-2016	БОАЖЯ		
3.17	Төвлөрсөн томоохон хот, суурин газрын ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлж, арчилгааг сайжруулах	2011-2016	БОАЖЯ	ЗТБХБЯ	
3.18	Ойжуулалт, ойн зурвас байгуулах чиглэлээр гадаад, дотоодын байгууллагуудтай хамтран төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, ой байхгүй газрыг ойжуулах, мод үржүүлэх шинэ дөвшилтэт технологийг судлан нэвтрүүлэх	2011-2016	БОАЖЯ		
3.19	Хатуу хот хаягдлыг ангилах, бүрэн боловсруулах, өргүүлэн ашиглах үйлдвэр байгуулах	2011-2016	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар		

Стратегийн зорилт 4: Уур амьсгалын ажиглалтын сүлжээг өргөтгөх, технологийн шинэчлэл хийх, судалгаа, шинжилгээ, үнэлгээний ажлыг өргөжүүлэх, боловсон хүчний чадавхийг дээшлүүлэх талаар		2011-2016	БОАЖЯ	
4.1	Ус, цаг уур, орчны хяналт шинжилгээний улсын сүлжээг өргөтгөх, технологийн шинэчлэлийг эрчимжүүлэх	2011-2016	БОАЖЯ	
4.2	Аэрологийн өргөөний хэвийн ажиллагааг хангах, ашиглалтыг сайжруулах	2011-2016	БОАЖЯ	
4.3	Нарны цацраг судлал, нарны гийгүүллийн хэмжилтийг сэргээн хийх	2011-2014	БОАЖЯ	
4.4	Тусгай хамгаалалттай газрыг түшиглэн биогеоценозийн ажиглалт, мониторингийн сүлжээг байгуулж эхлэх	2012-2016	БОАЖЯ	
4.5	Ус, цаг уур, орчны хяналт шинжилгээний улсын сүлжээг түшиглэн мөстөл цэвдэг, цөлжилтийн мониторингийн сүлжээг байгуулах	2011-2016	БОАЖЯ	ШУА
4.6	Өндөр уулын мөстөл судлалын сүлжээг Алтайн нуруунд байгуулах	2012-2016	БОАЖЯ	
4.7	Гадаргын болон гүний усны мониторингийн сүлжээг шинэчлэх, өргөтгөх	2011-2016	БОАЖЯ	
4.8	Дулааралтын улмаас шинээр гарч болзошгүй өвчин дамжуулагч шүмүүл, элдэв хортон, мэрэгчдийн мониторингийн сүлжээг бий болгох	2012-2016	БОАЖЯ	ЭМЯ, ХХААХҮЯ, ОБЕГ
4.9	Бэлчээрийн ургамлын болон цөлжилтийн мониторингийн сүлжээг өргөжүүлэх	2011 оноос	БОАЖЯ	ХХААХҮЯ
4.10	Монгол орны уур амьсгалын өөрчлөлтийн үнэлгээг 3-5 жил тутамд шинэчлэн хийх	2013	БОАЖЯ	
4.11	Уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй, дасан зохицох чадвартай ургамал, амьтны төрөл зүйлийн судалгаа хийх	2012-2016	БСШУЯ	ХХААХҮЯ, БОАЖЯ, ШУА
4.12	Ургамлын өвчин, хортны ажиглалтыг өргөжүүлэн, бэлчээрийн эрүүл ахуйн үнэлгээний арга технологи боловсруулах	2012-2016	БСШУЯ	ХХААХҮЯ, БОАЖЯ, ШУА
4.13	Хүлэмжийн хийн ялгаралт, шингээлтийн тооцооны үзүүлэлтүүдийг монгол орны нөхцөлд судлан тогтоох	2012-2015	БСШУЯ, БОАЖЯ	ШУА
4.14	Уур амьсгалын өөрчлөлтийн байгаль экологи, нийгэм, эдийн засгийн салбарт нөлөөлөх байдлын болон эрсдэлийн үнэлгээг тодорхой хийх	2012-2015	БОАЖЯ	ШУА



4.15	Дасан зохицох арга хэмжээний хувилбар, тэдгээрийн өргөтгөлд зардал-үр ашгийн тооцоог эдийн засгийн салбар тус бүрээр гаргах	2013 оноос	БОАЖЯ, ҮХШХ	Салбарын яамд, ШУА
Стратегийн зорилт 5: Олон нийтийг уур амьсгалын өөрчлөлтийн тухай мэдээллээр хангах, уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг үйл ажиллагаа, арга хэмжээнд идэвхтэй оролцоход нь дэмжлэг үзүүлэх талаар				
5.1	Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох талаар ном, товхимол, гарын авлага, материал бэлтгэн хэвлүүлэх	2011-2016	БОАЖЯ	БСШУЯ
5.2	Төр, засгийн бодлого, шийдвэр, шинжлэх ухааны ололт, дэвшилтэт технологийн тухай мэдээллийг олон нийтэд цаг тухайд нь хүргэх	2011-2016	БОАЖЯ	БСШУЯ
5.3	Уур амьсгалын өөрчлөлт, тогтвортой хөгжил, ногоон эдийн засгийн хөгжлийн тухай хичээлийг бүх шатны сургуулийн сургалтын хөтөлбөрт тусгах	2012-2016	БСШУЯ	ҮХШХ
5.4	Уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчны салбарт шинээр бий болох мэргэжлийн ангилал, индексийг тодорхойлох сургалтын хөтөлбөрийг боловсруулах	2012-2013	БСШУЯ	БОАЖЯ
5.5	Байгаль, цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдлийн мэдээллийг ашиглах, авран хамгаалах талаар сургалт, семинар, сурталчилгааны ажил тогтмол явуулах	2011-2016	ОБЕГ	БСШУЯ
5.6	Нутгийн иргэд, нөхөрлөлд түшиглэсэн гамшгаас хамгаалах багийг байгуулан ажиллуулах	2011-2016	ОБЕГ	БОАЖЯ
5.7	Аж ахуйн нэгж, байгууллага, нөхөрлөл, төрийн бус байгууллага, иргэдийн ногоон үйлдвэрлэл эрхлэх, түүний хөрөнгөөг нэмэгдүүлэх, бүтээмжийг дээшлүүлэх зэргээр уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг хариу арга хэмжээ авах үйл ажиллагааг дэмжих, урамшуулах	2011-2016	БОАЖЯ	Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар
5.8	Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаархи олон улс болон бус нутгийн арга хэмжээнд аж ахуйн нэгж, байгууллага, нөхөрлөл, төрийн бус байгууллага, иргэд, эмэгтэйчүүдийн оролцоог дэмжих, хамтын ажиллагааг өрнүүлэх	2011-2016	БОАЖЯ	Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар
5.9	Уур амьсгалын өөрчлөлтөд нийгмийн эмзэг бүлэг (өрх толгойгоос эмэгтэйчүүд, ядуу гэр бүл г.м)-ийн амьжиргааг дэмжих, ядуурлыг бууруулах, ногоон ажлын байрыг нэмэгдүүлэхэд чиглэсэн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх	2012-2016	НХХЯ	БОАЖЯ



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2011 оны 11 дүгээр
сарын 9-ний өдөр

Дугаар 318

Улаанбаатар
хот

Газрын тосны зарим бүтээгдэхүүний онцгой албан татварын тухай

Онцгой албан татварын тухай хуулийн 6.7-д заасныг үндэслэн
Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Импортоор оруулж байгаа автобензин, дизелийн түлшний
онцгой албан татварын хэмжээг 2011 оны 11 дүгээр сарын 11-ний өдрөөс
эхлэн дор дурдсанаар тогтоосугай:

№	Хилийн боомтын нэр	Ногдуулах онцгой албан татварын хэмжээ (төгрөгөөр)		
		Автобензин (шинжилгээний аргаар тодорхойлсон октаны хэмжээ)		Дизелийн түлш
		90 хүртэл	90 болон түүнээс дээш	
1	Цагааннуур, Ярант, Боршоо, Арцсуурь, Тэс, Бургастай, Гашуунсүхайд, Шивээхүрэн, Баянхошуу, Бичигт, Хавирга	0.0	0.0	0.0
2	Ханх, Ульханмайхан	0.0	0.0	0.0
3	Сүхбаатар, Замын-Үүд, Эрээнцав, Алтанбулаг	0.0	0.0	0.0

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Газрын тосны зарим
бүтээгдэхүүний онцгой албан татварын тухай” Засгийн газрын 2011 оны
8 дугаар сарын 17-ны өдрийн 248 дугаар тогтоолыг хүчингүй болсонд
тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАТБОЛД

**ЭРДЭС БАЯЛАГ,
ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД**

Д.ЗОРИГТ



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2011 оны 11 дүгээр
сарын 16-ны өдөр

Дугаар 324

Улаанбаатар
хот

Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Засгийн газрын 2006 оны 160 дугаар тогтоолоор баталсан “Хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, үр дүн, биелэлтийг дүгнэх, мэдээлэх журам”-ын Дөрөвдүгээр бүлэгт дор дурдсан агуулга бүхий 21, 22 дахь заалт нэмсүгэй:

“21. Төрийн захиргааны болон нутгийн захиргааны байгууллага нь Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтэд улирал бүр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, хагас, бүтэн жилийн тайланг сайд, агентлагийн даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэн, хагас жилийн тайланг 7 дугаар сарын 10-ны дотор, бүтэн жилийн тайланг дараа оны 2 дугаар сарын 1-ний дотор хурлын тэмдэглэл, санал дүгнэлтийн хамт Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороонд хүргүүлнэ.

22. Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороо нь Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийн дүнг жилийн эцсийн дараа оны I улиралд багтаан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.”

2. Мөн журмын 12-ын “улирал бүр дүгнэж” гэсний дараа “хагас, бүтэн жилийн хэрэгжилтийг сайд, агентлагийн дарга, Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэж” гэж, 15-ын “хяналтаас хасах санал боловсруулан” гэсний дараа “сайд, агентлагийн дарга, Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэж” гэж тус тус нэмсүгэй.

3. Мөн журмын 16-ын “г” заалтын “Засгийн газрын 2006 оны 51 дүгээр тогтоолоор баталсан “Яам болон аймаг, нийслэлийн Засаг даргын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх, үр дүнг үнэлэх журам”-ын



5.9-д заасныг” гэснийг “Засгийн газрын 2010 оны 11 дүгээр тогтоолоор батлагдсан “Яам болон аймаг, нийслэлийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх, үр дүнг үнэлэх журам”-ын 5.11-д заасныг” гэж, 17-гийн “8 дугаар сарын 20-ны дотор” гэснийг “8 дугаар сарын 1-ний дотор” гэж тус тус өөрчилсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАТБОЛД

**МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА**

Ч.ХҮРЭЛБААТАР

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2011 оны 11 дүгээр
сарын 16-ны өдөр

Дугаар 326

Улаанбаатар
хот

Мэргэжлийн боловсрол, сургалтын талаар авах зарим арга хэмжээний тухай

Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг үндэслэн Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Мэргэжлийн боловсрол, сургалтын талаар дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Ё.Отгонбаярт даалгасугай:

1.1. Мэргэжлийн боловсрол, сургалтыг хөгжүүлэх стратегийг тодорхойлж, чадамжид суурилсан тогтолцоог бүрдүүлэхэд чиглэсэн “Мэргэжлийн боловсрол, сургалтыг хөгжүүлэх мастер төлөвлөгөө”-г 2012 оны II улиралд багтаан боловсруулж батлах.

1.2. 2012-2013 оны хичээлийн жилээс эхлэн мэргэжлийн боловсрол, сургалтын багш бэлтгэх, мэргэшүүлэх, давтан сургаж чадваржуулахад чиглэсэн дэс дараатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

1.3. Мэргэжлийн боловсрол, сургалтын үйл ажиллагаанд ажил олгогчийн оролцоо, хариуцлагыг өндөржүүлэн, хөрөнгө, хүний нөөцийг үр



ашигтай зохицуулах зорилгоор яам хоорондын хамтын ажиллагааны гэрээ байгуулан 2 жил тутам дүгнэж ажиллах.

2. Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын хичээлийн болон дотуур байр, дадлагын газрыг өргөтгөх, дадлагын сургалтын бааз, лабораторийн техник, тоног төхөөрөмжийг шинэчлэх чиглэлээр хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, мэргэжлийн өөрийн өртөг, сургалтын стандартад суурилсан төсвийн тогтолцоог нэвтрүүлэх асуудлыг судалж шийдвэрлэхийг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Ё.Отгонбаяр, Сангийн сайд С.Баярцогт нарт үүрэг болгосугай.

3. "Оюутолгой", "Тавантолгой" зэрэг томоохон бүтээн байгуулалтын хөтөлбөр, төслийн хүрээнд мэргэжилтэй ажилтан бэлтгэх, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийг төгсөгчдийг ажлын байраар хангах талаар холбогдох байгууллага, аж ахуйн нэгжтэй зөвшилцсөний үндсэн дээр нэгдсэн төлөвлөгөө гаргаж үйл ажиллагааг нь уялдуулан зохицуулахыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Ё.Отгонбаяр, Эрдэс баялаг, эрчим хүчний сайд Д.Зоригт, Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд Х.Баттулга нарт даалгасугай.

4. Цэргийн алба хааж байгаа иргэдэд зохих түвшний мэргэжлийн чадамж эзэмшүүлэн гэрчилгээ олгох, тэднийг ажлын байранд зуучлах арга хэмжээг Батлан хамгаалах яам, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамтай хамтран авч хэрэгжүүлэхийг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Ё.Отгонбаярт даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАТБОЛД

**БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ
УХААНЫ САЙД**

Ё.ОТГОНБАЯР

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхтгэлийн редакци,
Улаанбаатар-12, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medecelel@parliament.mn

Утас: 262420, 329612
Хэвлэлийн хуудас 2.25

Индекс: 14003